



Evaluation Method in Strategy Development

Dovchinsuren Ganzorig

Ph.D, Center for military art studies, Defense Research Institute of Mongolia

ORCID: 0009-0006-5356-3132

Received: 05 February 2026

Revised: 15 March 2026

Accepted: 23 March 2026

Published online: 30 March 2026



ABSTRACT

Leadership must actively shape and direct the integration of technology and Artificial Intelligence. Leaders should exercise methodological discipline and strategic judgment, ensuring they are not subordinated to overwhelming data or to software-generated outputs that merely present an appearance of logical coherence. This article emphasizes the critical importance of mastering appropriate methodological frameworks of system analyses when conducting assessments within the broader process of policy (strategy) formulation. It provides a comparative examination of assessment methodologies employed by some Russian and Western scholars, with particular attention to the DIME framework as a conceptual and analytical tool.

Keywords: *Assessment, DIME, state institutions, military, national security, policy, strategy, capability, capacity, power.*

Стратеги боловсруулах үеийн үнэлгээ хийх аргын талаар

Довчинсүрэн Ганзориг

*Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн, Цэргийн урлаг судлалын төвийн
эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), ORCID: 0009-0006-5356-3132*

ХУРААНГУЙ

Удирдагч алба хаагчдадаа бодлого боловсруулах үйл явцад технологи болон хиймэл оюун ухааныг чиглүүлж, ашиглах чадварыг эзэмшүүлэх шаардлагатай байна. Удирдагчид системийн үнэлгээний аргазүйн зарчмыг чанд мөрдөж, их хэмжээний өгөгдөл болон логиктой мэт харагдах программын бүтээгдэхүүнд хэт автах бус, тэдгээрийг шүүн тунгаах чадвараа хадгалах ёстой. Өгүүлэл нь бодлого, стратеги боловсруулахад үнэлгээ хийхдээ зохистой аргазүй, аргачлалыг эзэмшихийн онцгой ач холбогдлыг тодотгож, орос болон барууны зарим судлаачдын хэрэглэдэг үнэлгээний аргыг тоймлон харьцуулан шинжилсэн болно. Үнэлгээний DIME аргыг тусгайлан авч үзсэн болно.

Түлхүүр үг: *Үнэлгээ, DIME, улс төр дипломат, мэдээлэл, цэргийн, эдийн засгийн, үндэсний аюулгүй байдал, бодлого, стратеги, чадавх, чадамж, хүч чадал.*

Оршил

Өнөө үед хүн амын ихэнх цахим орчныг ашиглан төрөл бүрийн мэдээллийг

богино хугацаанд олж авах боломжтой болсон. Үүнтэй зэрэгцэн хиймэл оюун ухаан ашиглаж баримт бичиг, дүгнэлт, шийдвэрийн төсөл гаргуулах хандлага эрчимжиж, хувь хүн өөрөө цахим ертөнцийн мэдээллийн урсгалын нэгэн ухамсаргүй дагагч бүрэлдэхүүн хэсэг болон хувирах эрсдэл бий болсон байна.

Нийгмийн цахим сүлжээн дэх хэрэглэгчдийн байр сууриа илэрхийлсэн сэтгэгдэл, санал, хэвлэл мэдээллийн хандлага, хиймэл оюун ухааны боловсруулсан санал дүгнэлтийг шүүн тунгаах, нягтлан шалгах шаардлага өсөн нэмэгдэж байгаа ч олон нийт энэ хэрэгцээг бүрэн ухамсарлаж чадахгүй байна. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн салбарт ажиллагсдын хувьд технологийн дэвшлийг зөв, зохистой ашиглах чадвар зайлшгүй шаардлагатай нэгэн болсон. Үндэсний аюулгүй байдлын асуудал судлаачдын, нийтлэгчдийн болон сонирхогчдын байр суурь, түүнчлэн хиймэл оюун ухааны гаргаж буй санал, дүгнэлтийг нягтлан үнэлэх чадвар нь бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцогч бүх түвшний алба хаагчид онцгой ач холбогдолтой болж байна.

Ийм чадварыг эзэмшсэнээр алба хаагч хиймэл оюун ухааныг оновчтой сургаж, удирдан ашиглах, шийдвэр гаргах үйл явцыг үр ашигтай зохион байгуулах, удирдлага зохион байгуулалтын цаг хугацаа хэмнэх, хэрэгжилтийг бодитой үнэлэх зэрэг олон давуу талтай болно. Хиймэл оюун ухааны хурдацтай хөгжил, түүний хэрэглэгчид үзүүлж буй нөлөөллийг харгалзан үзэж, удирдагч нь хиймэл оюун ухаанаар удирдуулах бус, харин түүнийг удирдан чиглүүлэх чадвараа тасралтгүй хөгжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Иймд бодлого (стратегийн) боловсруулах үеийн үнэлгээ хийх аргачлалын нэгэн хувилбарыг судлаачийн хувьд толилуульж байна. Стратеги (*Cambridge Dictionary 2026*) гэсэн үгийн олон утгаас энд “бодлого”, “стратегийн төлөвлөлт” гэсэн хоёр утгаар, стратегийн гэдгийг үндэсний, улсын хэмжээний гэсэн утгаар энэ нийтлэлд хэрэглэж байгаа болно.

Судалгааны аргазүй: Бодлого (стратегийн) боловсруулах үеийн үнэлгээ хийх энэхүү аргачлалыг системийн онол, арга зүй хүрээнд, дипломат, мэдээлэл, цэрэг, эдийн засгийн (DIME) үнэлгээний арга, харьцуулсан шинжилгээний аргуудыг хослуулан боловсруулсан болно.

Судалгааны үр дүн: Монгол Улсын нийгэмд төрийн алба хаагчдыг дотоодын болон гадаадын (барууны, оросын) байр суурь, номлолыг баримтлагч хэмээн ангилан харддаг, асуудлыг нухацтай, агуулгын хувьд бодож тунгаахын оронд цэцэрхэх, шийдвэр гаргах үйл явцыг улс төрийн буюу “үзэл суртал”-ын байр сууринаас тайлбарлах хандлага түгээмэл байна. Ийм хандлага нь бодит нөхцөл байдлын үнэлгээг гажуудуулах, улмаар оновчгүй шийдвэр гаргах эрсдэлийг өндөрсгөж байна.

Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн нэгэн чухал үр дүн болсон хиймэл оюун ухааныг ухаалаг, бүтээлч байдлаар, хариуцлагатай ашиглах шаардлага цаг үеийн зайлшгүй хэрэгцээ болж байна. Иймд, нөхцөл байдлыг бодитой үнэлэх, үндэслэлтэй дүгнэлтэд тулгуурлан шийдвэр гаргах сэтгэлгээний өөрчлөлт нь бодит нөхцөлд нийцсэн, Монгол Улсад зөв үр дүнтэй шийдвэрийн үндсэн суурь болж байх ёстой. Бодлого (стратегийн) боловсруулах үеийн үнэлгээ хийх аргачлалд төрийн алба хаагчдыг мэргэшүүлэн сургах шаардлагатай байна. Учир нь хиймэл оюун ухаан таны тавьсан асуултад ямар нэгэн хариулт өгнө. Түүнийг нягтлах

чадвар хүн бүрд зайлшгүй хэрэгцээтэй байгааг онцолж байна.

Стратегийн үнэлгээний арга зүйн үндэс ба загвар

Техникийн цогц системийг ашиглан ажиллагаа явуулж байсан цэргийн байгууллагын зохион байгуулалтын нэгжийн удирдлагад багтаж ажилсан алба хаагч нар бодит туршлагадаа тулгуурлан цэргийн ажиллагааг хэрэгжүүлэх боломж, хязгаарлалт, эрсдэлийн талаар сайн ойлголттой байдаг. Орчин үеийн цэргийн байгууллага нь хүн хүч, зэвсэглэл, техник, удирдлагын тогтолцоо, бүх төрлийн хангалт зэрэг олон бүрэлдэхүүн хэсэгтэй нарийн зохион байгуулалттай нэгдэл учраас түүнийг ашиглах бодлого боловсруулах нь өндөр түвшний дүн шинжилгээ, бүтээлч сэтгэлгээ шаардсан нарийн үйл явц юм. Бодлого/стратеги боловсруулах ажил нь зорилго, зорилт, нөхцөл байдал, боломж, хязгаарлалт, нөөц зэрэг олон хүчин зүйлийг системийн онол арга зүйгээр системтэй үнэлэхээс эхэлдэг.

Дэлхийн, бүс нутгийн, үндэсний аюулгүй байдлын цэрэгүлс төрийн орчныг судлахдаа системийн арга зүйг онолын хувьд ашиглах шаардлага байдаг. Учир нь үндэсний аюулгүй байдлыг хангах субъект нь зөвхөн улс орнууд бус, тэдгээрийн эвсэл холбоо, олон улсын болон дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, нийгмийн бүлэг, тэдгээрийн зорилго, ашиг сонирхол гээд харилцан хамаарлын цогц бүтэц байдаг. Эдгээр субъектүүдийн харилцааг бүхэлд нь шинжлэх нь тухайн улсын үндэсний аюулгүй байдлын, тэр дундаа цэрэгүлс төрийн бодит дүр зургийг тодорхойлох үндэс болдог.

Хоёр субъект хоорондын харилцаанаас үүдэлтэй үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлэх үйл явц, дайн, зэвсэгт мөргөлдөөн бий болох нөхцөл байдлыг үнэлэхдээ тухайн улсын язгуур эрх ашгийн үүднээс цогцоор нь харах нь чухал. Ийм нөхцөлд оролцогч талуудыг дэмжигч, холбоотон, дундыг баримтлагч, дайсагнагч, дайсан гэх мэт ангиллаар ялган, тухайн субъектийн ашиг сонирхлын үүднээс үнэлэх шаардлагатай. Өнөөгийн Сири улс дахь мөргөлдөөний талаарх өрнөдийн болон зүүний судлаачдын тайлбар харилцан адилгүй байдаг нь тухайн улсын ашиг сонирхол, үзэл баримтлалын нөлөө бодит байдлыг гажуудуулж болохыг харуулж байгаагийн нэгэн жишээ гэж үзэж байна. Иймээс стратегийн үнэлгээнд үзэл баримтлал, суртлын нөлөөг бодит нөхцөл байдлаас салгаж тооцох хэрэгтэй.

Судалгааны олон аргууд байна. Эдгээр аргыг зөв сонгох нь чухал. Жишээ нь, судалж байгаа сэдвийн хүрээнд “хамаарлыг тогтооход PMESII-PT / Political (улс төр), Military (цэрэг), Economic (эдийн засаг), Social (нийгэм), Information (мэдээлэл), Infrastructure (дэд бүтэц), Physical Environment (хүрээлэн буй биет орчин), Time (цаг хугацаа)”, “хэрэв тогтолцоо/систем нь тасалдвал юу бүтэлгүйтэх вэ? гэсэн гинжин холбоосыг тодорхойлоход системийн шинжилгээ”, “Энэ нь яагаад үндэсний аюулгүй байдлын асуудал вэ? гэснийг DIME арга”, “Төр юу хийх ёстой вэ? гэвэл DIME аргын хүрээнд бодлогын шийдвэр” боловсруулдаг байна. Эдгээр бүх аргыг ашиглахад системийн онол арга зүйг баримтална.

Болзошгүй үндэсний аюулгүй байдал, тэр дундаа цэрэгүлс төрийн аюул заналыг тодорхойлохдоо дараах үндсэн хүчин зүйлсийг үнэлнэ. Үүнд: субъект хоорондын ашиг сонирхлын харилцаа; оролцогч талуудын улс төрдипломат, эдийн засаг, цэргийн болон мэдээллийн чадавх; үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын үзэл баримтлал, стратеги; мөн тухайн субъектийн дотоод

улс төр, нийгмийн нөхцөл байдал хамаарна. ОХУ-ын судлаач Попов И.М. болон Хамзатов М.М. нар эдгээр хүчин зүйлсийг материаллаг (эдийн засаг, цэрэг, нөөц, технологи) болон материаллаг бус (улс төр, мэдээлэл, соёл, сэтгэлгээ) гэж ангилж болохыг тэмдэглэсэн байдаг (*Popov and Khamzatov 2018*).

АНУ-ын батлан хамгаалах салбар 2003 он хүртэл стратегийн үнэлгээнд DIME (дипломат, мэдээллийн, цэргийн, эдийн засгийн) загварыг ашиглаж байсан бол 2003 оноос хойш FII (санхүү, тагнуул, хууль сахиулах) чиглэлүүдийг нэмснээр институт хоорондын чадавхыг илүү өргөн хүрээнд үнэлдэг болсон гэж зарим судлаачид үздэг (*Feild Manual FM 3-0 Operations 2022*). Энэ өөрчлөлт АНУ-ын үндэсний аюулгүй байдлын стратегийн баримт бичгүүдэд тусгагдсан бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангахад санхүүгийн тогтолцоо, тагнуулын чадавх, хууль сахиулах байгууллагын үүрэг улам бүр чухал болсныг харуулж байна гэж судлаачид үздэг. 2019 онд Их Британи болон НАТОгийн “Эвслийн цэргийн нэгдсэн хэвлэл” номлолд стратегийн үнэлгээнд DIME аргыг ашиглахыг албан ёсоор заасан байдаг (*NATO and Ministry of Defence (UK) 2019*).

Стратегийн үнэлгээний оноларга зүйн чухал бүрэлдэхүүн нь Клаувицийн “хүндийн төв” болон “эмзэг цэг”-ийг тодорхойлох арга юм (*Strange 2005*). Энэ нь субъектийн чухал, эмзэг, сул хэсгүүдийг илрүүлж, тэдгээрийн аюулгүй байдлын системийн бусад бүрэлдэхүүнтэй уялдааг тогтоох боломж олгодог. Үнэлгээний эцсийн дүгнэлт, шийдвэрийн хувилбарыг боловсруулахдаа тухайн субъектийн соёлын онцлог, боловсролын түвшин, сэтгэлгээний хэв маягийг харгалзан үзэх нь түүний зан төлөвийг зөв тодорхойлох үндэс болдог.

Эдгээр бүх өгөгдлийг нэгтгэн үзвэл стратегийн үнэлгээний арга зүй нь оноларга зүйн үндэс, үнэлгээний чиглэлүүд, институт хоорондын уялдаа, үнэлгээний шалгуур, дүгнэлт гаргах логикийг системтэйгээр багтаасан цогц бүтэц болох нь тодорхой. Энэ арга зүй нь ОХУ-ын уламжлалт геополитикцэргийн шинжилгээ болон АНУ/НАТОгийн институт хоорондын уялдаанд суурилсан DIME загварын аргыг нэгтгэн, үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулахад өндөр системийн шинжтэй үнэлгээ хийх боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

DIME үнэлгээний аргын гол агуулгыг дараах байдлаар авч үзэж болно.

Дипломат (улс төр дипломат), мэдээлэл, цэргийн болон эдийн засгийн институтийн чадавх нь тухайн улсын төрийн эрх мэдэл, хүч, чадлыг илэрхийлдэг дөрвөн тулгийн чулуу гэж үзэж болно. DIME үнэлгээ нь улс (тухайн асуудалд хамаарал бүхий субъект) стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд төрийн эрх мэдэл, хүч хэрэгслийн дөрвөн тулгуур институтийг хэр үр дүнтэй ашиглаж байгааг үнэлдэг. Энэ үнэлгээг чиглэл тус бүрээр тоймлон авч үзье.

1. Улс төр, дипломатын чадавх

Улс төр нь нийгмийн харилцааг зохицуулах тухай томъёолол билээ. Дипломат үйл ажиллагаа бол зөвхөн хэлэлцээр хийх биш, харин олон улсын тогтолцоонд байр сууриа тогтоох урлаг юм. Судлагдаж буй субъектийн ямар чиглэлийн, хэдий хэмжээтэй олон улсын дэмжлэг боломжтой эсэхийг үнэлнэ. Мөн олон улсын болон гадаад улсын дэмжлэг авахад төрийн бусад чадавхуудыг хэрхэн ашиглаж байгаа байдал зэрэг хүчин зүйл улс төр, дипломатын чиглэлийн үнэлгээг гаргахад хэрэгтэй болно. Судлагдаж байгаа субъектийн дипломат харилцааны нөлөөллийг

үнэлэхэд хоёр талын болон олон талт харилцааны онцлогийг тоймлож авч үзье.

Хоёр талын оролцоо (bilateral engagement)

Энэ нь хоёр улсын хоорондын шууд харилцаа гэсэн үг. Жишээ нь, АНУ–БНХАУ хоёр талын харилцаа. АНУ ба БНХАУ хоёрын худалдаа, хөрөнгө оруулалт, технологийн өрсөлдөөн нь зөвхөн хоёр улсын асуудал биш, дэлхийн эдийн засагт шууд нөлөөлдөг. Хоёр талын харилцаа муудахад дэлхийн зах зээлд савлагаа үүсдэг (жишээ нь: тарифын дайн, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний доголдол). Тэгэхээр хоёр талын харилцаа нь дэлхийн эдийн засгийн тогтвортой байдалд шууд нөлөө үзүүлдэг.

Олон талт оролцоо (multilateral engagement) нь олон улсын байгууллага, эвсэл, гэрээний хүрээнд олон улс хамтран ажиллах гэсэн утгатай. Энэ харилцааны жишээ нь Европын Холбоо (ЕХ). ЕХ нь 27 гишүүнтэй, хамтын шийдвэрээр стандартаа тогтоодог (жишээ нь: бүтээгдэхүүний чанарын стандарт, хүний эрхийн зарчим, худалдааны дүрэм). ЕХ-ын тогтоосон стандартуудыг дэлхийн бусад улс дагаж мөрдөх шаардлагатай болдог, учир нь ЕХ бол дэлхийн том зах зээлүүдийн нэг. ЕХ-ны олон талт оролцоо нь дэлхийн тогтолцоонд дүрэм, хэм хэмжээ тогтоох хүчтэй механизм болж байна.

Хоёр талын (bilateral) болон олон талт (multilateral) оролцооны давуу ба сул талын харьцуулсан хүснэгтээр харьцуулж шинжье:

Төрөл	Давуу тал	Сул тал
Хоёр талын оролцоо	<ul style="list-style-type: none"> - Шууд, хурдан шийдвэр гаргах боломжтой. - Хоёр улсын ашиг сонирхлыг тодорхой тусгадаг. - Уян хатан, тохиролцоонд хүрэхэд хялбар. 	<ul style="list-style-type: none"> - Хоёр улсын харилцаанд хэт найдах эрсдэлтэй. - Гуравдагч улсууд үл оролцох тул олон улсын дэмжлэг байхгүй. - Хүчний тэнцвэргүй байдлаас хамаарч нэг тал давамгайлж болзошгүй.
Олон талт оролцоо	<ul style="list-style-type: none"> - Олон улсын хэм хэмжээ, дүрэм тогтоох чадвартай. - Илүү өргөн хүрээний дэмжлэг, хууль ёсны байр суурь олж авдаг. - Бүс нутгийн болон дэлхийн тогтвортой байдалд хувь нэмэртэй. 	<ul style="list-style-type: none"> - Шийдвэр гаргалт удаан, төвөгтэй. - Улс бүрийн ашиг сонирхол зөрчилдөж, тохиролцоонд хүрэхэд хүндрэлтэй. - Заримдаа бодит хэрэгжилт сул байдаг.

Хоёр талын оролцоо нь шууд, хурдан нөлөөтэй боловч хязгаарлагдмал хүрээтэй. Олон талт оролцоо нь өргөн хүрээний хууль ёсны байр суурь, стандарт тогтоох чадвартай боловч удаан, төвөгтэй.

Улс төр, дипломат чадавх нь бусад гурван чадавхыг (мэдээлэл, цэрэг, эдийн засаг) нэгтгэх гол зангилаа болдог.

2. Мэдээллийн чадавх

Мэдээлэл бол XXI зууны хамгийн хурдан нийгэм, түүнийг зохицуулж буй улс төрийн нөлөөллийн хэрэгсэл. Энэ чадавхыг үнэлэхэд мэдээллийн хэрэгсэл төрийн хяналтад байгаа эсэх, мэдээллийн хэрэгслээр олон улсад нөлөөлөх чадавх, тухайн субъектийн мэдээллийн хэрэгсэлд иргэд нь итгэдэг эсэх зэрэг хүчин зүйлийг үнэлэх хэрэгцээ гарна. Мэдээллийн хэрэгсэл тухайн улсын иргэдийг нэгтгэх, төр иргэдийн

дэмжлэгийг авах зэрэг олон чиглэлийн чадавх, боломжийг өөртөө агуулж байдаг гэдгийг үнэлгээ хийхдээ харгалзах хэрэгтэй.

Стратегийн харилцаа, харилцан ажиллагаа, төр засгийн үйл ажиллагааны зорилгыг олон нийтэд түгээх, түүний дэмжлэг авах зорилго бүхий мэдээ, хураангуйлсан товч агуулга бүхий томьёоллын жишээ болгож дараах түгээмэл мэдээ, сурталчилгааг энд оруулав. Үүнд, Америкийн “зөөлөн хүчний” кампанит ажил “Америк хүн дэлхийн нэгдүгээр хүн”, “Америк мөрөөдөл”, БНХАУ-ын “Зам ба Бүс санаачилга” (дэд бүтцийн том төсөл боловч хятадын том мэдээллийн нөлөөллийн төсөл) нь төр засгийн үйл ажиллагааны том, товч мэдээ юм. Эдгээр мэдээ, мэдээллийг стратегийн өнгөлөн далдлалт гэж шинжиж үзэх нь ач холбогдолтой.

Хэвлэл мэдээллийн экосистем ба өгүүлэмжийн хяналт: CNN, BBC зэрэг хэвлэлийн компаниуд дэлхийн мэдээллийн урсгалыг тодорхойлдог. Харин ОХУ-ын RT, БНХАУ-ын CGTN-аар улс, байгууллага, эсвэл бүлгийн өөрийн хүссэн түүх, тайлбар, үзэл санаа, мессежийг түгээдэг байна. Өөрөөр хэлбэл, RT, CGTN нь олон нийт, олон улсын тавцанд ямар өнцгөөс, ямар үгээр, ямар утгаар үйл явдлыг ойлгох нь чухал вэ? гэсэн санааг түгээдэг. Иймд, мэдээллийн үнэн, бодит байдлыг нягтлан үнэлэхэд дээрх хэвлэл мэдээллийн хэрэгслийн агууламж, эзэмшлийг мэдэж байх нь чухал.

Кибер чадавх ба мэдээллийн аюулгүй байдал: энэ чиглэлийн үнэлгээ хийхэд хүндрэлтэй олон зүйл байна. Үнэлгээг бодлого, төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, нийгмийн цахим орчим дахь соёл, санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа гэх мэт чиглэлээр гаргаж болно.

Нөлөөллийн үйл ажиллагаа ба сөрөг нөлөөлөл: Хамаарал бүхий асуудлын хүрээнд субъектийн нөлөөллийн (мэдээллийн) үйл ажиллагааны үнэлгээ гаргахдаа хуурамч мэдээ/Fake news, Хиймэл оюун ухааны тусламжтай хийсвэр мэдээлэл хийх технологи/deepfake нь мэдээллийн дайны шинэ хэрэгсэл болоод байгааг анхаарах хэрэгтэй.

Ил тод байдал ба итгэл үнэмшил: Швед, Финландын нээлттэй засаглал өөрсдийн иргэдийн итгэлийг бодит, үнэн мэдээ мэдээллийг мэдээллийн хэрэгслээр түгээж олж авдаг. Болж буй үйл явц, бодит нөхцөлийг иргэдэд хүргэснээр төр засагт иргэд, нийгмийн дэмжлэгийг олж авахад чухал үүрэгтэй байна. Энэ чиглэлийн үнэлгээг хийхдээ төр засаг, улс төрчид иргэдэд мэдээллийг бүрэн болон бодит байдлаар толилуулдаг эсэх, хувийн ашиг сонирхлыг үүднээс мэдээ, мэдээллийг гуйвуулдаг эсэхийг үнэлнэ.

Мэдээллийн чадавх бол бусдыг итгүүлэх, төөрөгдүүлэх, эсвэл урамшуулах замаар стратегийн зорилгод хүргэхэд чухал хэрэгсэл мөн.

3. Цэргийн чадавх

Цэрэг бол зөвхөн дайтах биш, сэргийлэх хэрэгсэл. Цэргийн чадавхыг үнэлэхэд дараах хүчин зүйлсийг тус бүрээр үнэлдэг. Бэлэн байдлын үнэлгээний талаар улс орон бүр өөрийн арга, аргачлалтай. Нууцын зэрэглэлтэй байдаг тул уншигч танд төсөөлөл болгож зарим зүйлд жишээ татах байдлаар агуулгыг хүргэж байна (*Feild Manual FM 3-0 Operations 2022*).

Зэвсэгт хүчний бүтэц, түүний нэгжүүдийн байршил ба бэлэн байдал:

Асуудалд хамаарах субъектүүдийн цэргийн бүлэглэл байршил, хэмжээ, төрөл, бэлэн байдалтай хамааралтай бусад зүйлсийг үнэлнэ.

Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтын ашиглаж буй байдал: Үүнд, жишээ болгоход дроны ашиглалт, хиймэл оюун ухаан, кибер дайралт хийх чадавх зэргийн үнэлгээг тусгана.

Удирдлага, хяналт, харилцан ажиллагааны зохицуулалт: Судлагдаж байгаа субъектүүдийн цэргийн байгууллагын нэгдсэн удирдлагын тогтолцоо, холбоо мэдээллийн сүлжээ, автоматжуулагдсан байдал, шийдвэр гаргах үйл явц зэргийг үнэлнэ.

Батлан хамгаалах бодлого: хориглох агуулгатай юу? Давших агуулгатай юу? Газар нутгийн хэмжээ нь ямар нөлөөтэй бэ? Гээд олон асуудлыг судлах ёстой. Жишээ нь, ОХУ-ын өргөн газар нутаг нь стратегийн маневрын их өргөн уудам орон зайг өгдөг. Израил: Газар зүйн орон зай маш бага (газар нутаг нарийн, жижиг), тиймээс хамгаалалтын бодлого нь хурдан хариу өгөх, урьдчилан сэргийлэх цохилт хийхэд төвлөрдөг. Өмнөд Солонгос нь газар нутаг жижиг тул хамгаалалтын гүн бага, тиймээс АНУ-тай холбоотны харилцаатай байж, технологийн давуу талд анхаарал хандуулдаг байна. Иймд, батлан хамгаалах бодлогын агуулгыг сайн судлах, үнэлэх хэрэгтэй.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа: судлагдаж байгаа субъектүүдийн гадаад харилцаа нь цэргийн чиглэлийн үнэлгээ хийхэд зайлшгүй анхаарах асуудал байна. Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа нь цэргийн үйл ажиллагаа явуулах боломж, нөөцийг нэмэгдүүлж, хүчжүүлж өгч байдаг. Жишээ нь, QUAD/Дөрвөл (АНУ, Энэтхэг, Япон, Австрали) цэргийн хамтын ажиллагаа, НАТО, Шанхайн Хамтын ажиллагааны байгууллагын гишүүн эсвэл оролцогч, ажиглагч байр суурь нь батлан хамгаалах салбарын гадаад харилцааны үзүүлэлт болж болно.

Цэргийн чадавх нь улс төр, дипломат зорилгыг баталгаажуулах ба тус улсын мэдээлэл, эдийн засгийн чадавхыг хамгаалдаг хүчин зүйл.

4. Эдийн засгийн чадавх

Эдийн засаг бол бусдыг хүчээр биш, нөлөөллөөр татах хэрэгсэл. Эдийн засгийн үнэлгээг дараах үзүүлэлтээр ихэвчлэн хийдэг. Үүнд:

ДНБ-ий хэмжээ ба өсөлт: ДНБ-ий хэмжээ нь тухайн улсын эдийн засгийн нийт хэмжээг илэрхийлдэг бол ДНБ-ий өсөлт нь эдийн засаг хэр хурдан тэлж, баялаг нэмэгдэж байгааг харуулдаг. ДНБ-ны хэмжээ, түүний өсөлт нь тухайн субъект дайны ажиллагааг хэдий хугацаанд хийх боломжтойг тодорхойлох нэг үзүүлэлт.

Байгалийн баялаг, түүхий эдийн нөөц ба эрчим хүчний аюулгүй байдлын талаар. Улс орон өөрийн байгалийн баялаг, түүхий эдийн нөөцөө хэр хэмжээнд хадгалж, ашиглаж чадаж байгааг, улс орон эдийн засгийн болон стратегийн хувьд өөрийгөө хангах чадвартай эсэхийг үнэлнэ. Жишээ нь, Саудын Араб нефтийн нөөцөөр дэлхийн зах зээлд нөлөөлдөг, Монгол Улс нүүрс, зэсийн томоохон нөөцтэй ч боловсруулах хүчин чадал хязгаарлагдмал тул зах зээлд нөлөө үзүүлэх нь маш бага.

Худалдааны сүлжээ ба зах зээлд нэвтрэх боломжийн талаар. Худалдааны

сүлжээ нь улс орон бусад улсуудтай хийдэг худалдааны харилцаа, гэрээ, тээвэр, логистикийн сүлжээний цогц юм. Улс орон дэлхийн зах зээлд хэр холбогдсон, ямар түншүүдтэй, ямар гэрээний хүрээнд бараа бүтээгдэхүүнээ нийлүүлж, авч байгааг харуулдаг. Жишээ нь, Европын Холбоо дотоодын чөлөөт худалдааны сүлжээгээр гишүүн орнуудын бараа чөлөөтэй урсдаг. БНХАУ-ын “Belt and Road Initiative” нь тус улсын худалдааны сүлжээг өргөжүүлэх стратеги. Монголын хувьд Хятад, Орос хоёр гол худалдааны түнш бөгөөд сүлжээ нь хязгаарлагдмал. **Зах зээлд нэвтрэх боломж** нь улс орон өөрийн бараа, үйлчилгээг гадаадын зах зээлд гаргах боломж, нөхцөл гэсэн утгатай. Татвар, стандарт, улс төрийн харилцаа, логистикийн хүчин зүйлсээс хамаарч бараа бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргах боломжтой эсэхийг авч үздэг. Жишээ нь, Солонгос, Япон зэрэг улс өндөр технологийн бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд өргөн хүрээнд гаргах боломжтой. Гэхдээ, тус улсын бараа зах зээлд татвар, стандарт, улс төрийн нөхцөлөөс шалтгаалан хэр амжилттай нэвтэрч чадаж байгаа нь чухал. ОХУ-Украин хоорондын дайнаас хамаарч ОХУ-ын зах зээлд улс төрийн нөхцөлийг даван туулж орох нь томоохон сорилт болж байна.

Санхүүгийн хөшүүрэг ба хөрөнгө оруулалтын нөлөөний талаар.

Санхүүгийн хөшүүрэг гэж улс орон эсвэл байгууллага өөрийн санхүүгийн нөлөөллийг ашиглан бусдад дарамт үзүүлэх, эсвэл бодлогоо хэрэгжүүлэх чадвар. Энэ нь зээл, тусламж, санхүүгийн зах зээлд нөлөөлөх, валютын бодлогоор бусдыг чиглүүлэх үйл явцаар тодорхойлогдож байдаг. АНУ долларын нөлөөг ашиглан бусад улсад хориг тавих, Олон улсын валютын сан (IMF) зээл олгохдоо бодлогын нөхцөл тавьж, улс орны эдийн засгийн чиглэлийг тодорхойлдог, БНХАУ бусад улсад зээл олгох замаар улс төрийн нөлөө тогтоодог (“debt diplomacy”) гэх жишээнүүд байна. Хөрөнгө оруулалтын нөлөө нь улс орон эсвэл байгууллага өөрийн хөрөнгө оруулалтын чадавхаар бусдад нөлөөлөх, улс, байгууллагын эдийн засгийн өсөлт бий болгох чадвар гэж тодорхойлогдож байна. Үүний гол агуулга нь гадаадын хөрөнгө оруулалт хийх/авах, дотоодын хөрөнгө оруулалтаар эдийн засгаа тэлэх, технологи, дэд бүтцийг хөгжүүлэх гэдгээр илэрхийлэгдэж байна. БНХАУ-ын “Зам ба Бүс санаачлаг” нь хөрөнгө оруулалтын замаар олон улсад үзүүлж буй нөлөөлөл, АНУ-ын компаниуд дэлхийн технологийн салбарт хөрөнгө оруулалт хийснээр инновацын давамгайл байр суурийг хадгалж буй байдал, Сингапур жижиг улс боловч хөрөнгө оруулалтын хүчээр бүс нутгийн санхүүгийн төв болсноор дэлхийн улс төр, эдийн засагт өөрийн нөлөө бүхий байр суурийг бий болгосон гэх жишээнүүд байна. Үүнтэй төстэй, эсвэл дээрх байгууллагууд судлагдаж буй субъектийн газар нутаг дээр байгаа эсэх, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх зэргийг санхүү, хөрөнгө оруулалтыг суллах үед үнэлэх хэрэгтэй.

Дэд бүтэц ба технологийн бааз нь улс орны эдийн засаг, нийгмийн үйл ажиллагааг дэмжих суурь байгууламж, системүүдийн цогц гэж ойлгодог. Үүнд:

- **тээвэр:** авто зам, төмөр зам, нисэх буудал, боомт;
- **эрчим хүч:** цахилгаан станц, дамжуулах шугам, шатахуун хадгалах байгууламж;
- **холбоо, мэдээлэл:** интернэт, харилцаа холбооны сүлжээ;
- **хот, суурин газрын дэд бүтэц:** усан хангамж, бохир ус, орон сууц, эмнэлэг, сургууль.

Дэд бүтэц сайн хөгжсөн улс орон эдийн засгийн үйл ажиллагааг үр ашигтай, тогтвортой явуулж чаддаг.

Дэлхийн улс орнуудаас Япон, Герман, Сингапур, Өмнөд Солонгос технологийн инновацаар эдийн засгаа бэхжүүлж чадсан жишээ улсууд билээ. Тиймээс дэд бүтцийн үнэлгээ нь эдийн засгийн чадавхыг тогтооход чухал.

Эдийн засгийн чадавх нь урт хугацааны стратегийн бие даасан байдал болон бусдад нөлөөлөх чадварыг бий болгодог.

Нэгтгэн уялдуулах шинжилгээ

DIME-ийн чадавхыг тус тусад нь биш, харин хооронд нь уялдуулж, нэгтгэн үнэлэх ёстой. DIME (Diplomacy, Information, Military, Economy) гэсэн төрийн институц нь тус бүрдээ хүчтэй, нөлөөтэй боловч бодит амьдрал дээр тус тусдаа биш, эдгээрийн хоорондын уялдаа холбоо жинхэнэ стратегийн хүч, чадавхыг бий болгодог (*Ronnie S. Catpon 2026*).

Уялдуулж, нэгтгэн үнэлэх нь

● **Улс төр, дипломат + Цэрэг:** Зөрчилдөөнөөс зайлсхийх, ашигтай тохиролцоо хийх боломжийг нээх, цэргийн байрлалыг дипломат хэлэлцээрээр баталгаажуулах зэрэг үйл явц дипломат чиглэлийн үйл ажиллагаанд хамаарна. Үүний жишээ болгож олон улсын эрх зүйн нь хилийн бүсэд цэргийн ангийг байгуулах, байршуулахыг хориглодог. Нөгөө талаас, цэргийн чадавх нь итгэлцлийн баталгаа ч болох талтай. Мөн цэргийн чадавх нь хэлэлцээрийн явцад илүү хүчтэй байр суурьтай оролцох боломжийг хангадаг. Жишээ нь, Өмнөд Солонгосын дипломат зорилго АНУ-ын дэмжлэгийг авч, үндэсний аюулгүй байдлаа хангах зорилго тээж явдаг, АНУ-БНСУ хоорондын цэргийн хамтын ажиллагаа нь хэлэлцээрийг бодитой болгодог. Энэ нь улс төрийн зорилгыг цэргийн хүчээр баталгаажуулах бодлого, үйл явцын ч жишээ болж байна. Дипломат (гадаад бодлогын) байр суурь нь олон улсын дэмжлэгийг авахад чухал бол цэргийн хүч нь бодит хүчин чадлыг харуулдаг ба энэ хоёр институтын чадавх уялдсанаар ухаалаг хүчний бодлого хэрэгжих нөхцөл бүрддэг гэж үзэж байна.

● **Мэдээлэл + Эдийн засаг:** Соёлын зөөлөн хүчний бодлого, түүний хэрэгжилт эдийн засгийн тэлэлтэд таатай нөлөө үзүүлдэг. Мэдээлэл сайн эерэг байх тусам зах зээл ил тод болно. Ил тод байдал нь эрсдэлийг бууруулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, илүү их хөрөнгө татна. Жишээ нь, БНСУ-ын К-поп, технологийн брэндүүд нь тус улсын эдийн засгийн экспортын стратегийг бэхжүүлэхэд ач холбогдолтой байна гэж үзэж байна. Нөгөө талаас, мэдээлэл гэдэг өгөгдөл. Мэдээллийн систем, дата анализ зэрэг нь бодлого боловсруулах чанарыг сайжруулж, эдийн засгийн шийдвэрүүдийг илүү оновчтой, үр ашигтай болгож байна. Мэдээллийн нөлөөллийг (хэвлэл, олон нийтийн цахим сүлжээ) нийгмийн зан төлөвийг өөрчлөхөд ашиглаж, зах зээлийн борлуулалт, эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, брэндийн үнийг өсөгдөг. Стратегийн түвшинд, мэдээллийн институтын үйл явцыг үзвэл, мэдээллийн дайн нь эдийн засгийн хориг арга хэмжээг илүү үр дүнтэй ч болгодог байна.

● **Цэрэг + Эдийн засаг:** батлан хамгаалах хүчин чадал болон эдийн засгийн нөөц хоорондоо харилцан уялдан бэхжиж, улс оронд стратегийн давуу байдлыг бий болгодог. Энэ хослолыг их гүрнүүд үндэсний хүчний гол тулгуур гэж үздэг.

Эдийн засаг нь батлан хамгаалах салбартаа хөрөнгө оруулдаг хэлбэрээр бие биеэ нөхдөг тогтолцоо үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Зэвсэглэл, цэргийн технологи, сургалт, хангалт зэрэг нь бүгд улс орны эдийн засгийн чадавх дээр тулгуурладаг. Нөгөө талаасаа, цэргийн хүч нь худалдааны зам, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн аюулгүй байдлыг хангадаг. Батлан хамгаалах салбарын цэрэг аж үйлдвэрийн нэгж нь өндөр технологи, түүний үйлдвэрлэл, инновацыг хурдасгадаг. Энэ нь иргэний салбарын инновац, хөгжилд ч дэмжлэг болдог онцлогтой. Хүчтэй зэвсэгт хүчинтэй улс орнууд эдийн засаг(эрчим хүч, худалдаа, тээвэр)- ийн бодлогоо илүү үр дүнтэй хамгаалдаг.

Дипломат + Мэдээлэл: Улс өөрийн өгүүлэмжийг олон улсын тавцанд түгээх замаар дипломат нэр хүндээ өсгөдөг. Түүнчлэн, мэдээллийн кампанит ажиллагаа нь олон нийтийн ойлголт, сэтгэл зүйд нөлөөлнө. Мэдээллийн урсгалыг зөв удирдвал дипломат хэлэлцээр үр дүнтэй болдог. Мэдээллийн стратеги нь дипломат хэлэлцээрийн чухал хэрэглэл байдаг тул энэ дипломат, мэдээллийн үнэлгээний уялдаа, үр нөлөөг зөв үнэлэх нь чухал байна. Энд зөөлөн хүчний бодлогын үр дүн, нөлөөг заавал тооцно. Түүнчлэн, мэдээлэл-дипломатын хосолсон ажиллагаа хямралын үед чухал нөлөөтэй гэдгийг харгалзан тооцох хэрэгтэй.

Уялдуулж, нэгтгэн үнэлэхийн үнэлэхийн ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Үндэстэн, улс орон бүх төрийн тулгуур институтийг нэгтгэн “бидний зорилго юу вэ?” гэсэн тодорхой агуулга бүхий мэдээг нийтэд хүргэх.
- Сул, эмзэг байдлыг тодорхойлох. Хэрэв нэг салбар сул байвал бусдыг ч сулруулна. Жишээ нь, эдийн засаг сул бол дипломат байр суурь ч сулрах магадлалтай.
- Стратегийн бие даасан байдлыг бэхжүүлэх, баталгаажуулах, хөгжүүлэх. Төрийн институт хоорондын уялдаа сайн байвал улс орон гадаад улс орны дарамтад бага өртөнө.

Уялдуулж нэгтгэн үнэлэхэд үнэлж буй улс орны (субъектийн) онцлогийг системийн онол арга зүй, аюулгүй байдлын болон бусад онол арга зүйн талаар мэдлэгтэй байж үнэлгээг гаргана.

Энэ уялдуулж, нэгтгэн үнэлэхийн утгыг БНСУ дээр тоймлон гаргаж үзье.

Хүснэгт 1. DIME жишиг үнэлгээ

(БНСУ-ыг жишээ болгож үлгэрчилсэн байдлаар өгсөн үнэлгээ)

Хэмжээс	Бие даасан хүч	Уялдуулж нэгтгэн үнэлэх
Дипломат	АНУ-тай батлан хамгаалах чиглэлээр холбоотон, олон улсын байгууллагад идэвхтэй гишүүнчлэлтэй, түүний үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог Хүндийн төв: АНУ-тай байгуулсан цэргийн холбоо. Эмзэг хэсэг: тус улсын олон улсын байр суурь сул, БНСУ-ын гадаад бодлогыг АНУ-ын гадаад бодлогын үргэлжлэл гэж хардаг байдал түгээмэл байдаг.	Цэргийн чадавх, байр суурь нь дипломат хэлэлцээрийг баталгаажуулж, хөшүүрэг болж явдаг. Соёлын дипломат (К-поп) нь эдийн засгийн экспортын стратегийг дэмждэг.

Мэдээлэл	К-поп, кино, технологийн брэндүүдээр дэлхийд Солонгосын талаар эерэг мэдээ, сэтгэгдэл, бодлыг түгээдэг. Хүндийн төв: Солонгос ард түмэн. Эмзэг төв: солонгос хэлний хэрэглээ залуучуудын дунд багассан.	Эдийн засгийн бүтээгдэхүүн (Samsung, Hyundai) нь мэдээллийн өгүүлэмжийг бэхжүүлж, дипломат нэр хүндийг өсгөдөг.
Цэргийн	Зэвсэгт хүчин нь 390,000 алба хаагчтай, АНУ-ын технологийн дэмжлэгтэй, удирдлага, зохион байгуулалтын хувьд БНСУ, АНУ-ын цэргийн удирдлага амархан бие биедээ нэгдэн, харилцан ажиллах боломжтой. БНСУ-ын газар нутаг дээр АНУ-ын цэргийн бааз байрлаж байна. Хүндийн төв: АНУ-тай байгуулсан цэргийн холбоо. Эмзэг хэсэг: газар зүй.	Хойд Солонгосын аюулаас сэргийлэх батлан хамгаалах бодлого/ стратеги нь дипломат зорилгыг шууд дэмждэг. Батлан хамгаалахын технологи нь эдийн засгийн инновацын бааз болж байна.
Эдийн засаг	~2 их наяд ам.доллар, хагас дамжуулагч, автомашин, электроникийн чиглэлийн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжсөн, дэлхийн олон улстай худалдаа хийдэг. Хүндийн төв: бүтээгдэхүүний чанар. Эмзэг, сул тал: гадаад зах зээлээс нэлээдгүй хамааралтай.	Эдийн засгийн чадамж нь мэдээллийн өгүүлэмжийг (Korean Wave/ Солонгосын давлагаа) дэлхийд түгээх хөрөнгийг бий болгодог. Тус улсын дипломат нэр хүндийг эдийн засгийн чадамж дэмждэг.

Нэгдсэн дүгнэлт гаргах нь

- **Дипломат + Цэрэг:** АНУ-тай холбоо нь Хойд Солонгосын аюулыг сэргийлэхэд бодит баталгаа болж байна.
- **Мэдээлэл + Эдийн засаг:** К-поп, технологийн брэндүүд нь экспортын бодлогын хэрэгжилтийг бэхжүүлж, Солонгосын нэр хүндийг өсгөдөг.
- **Цэрэг + Эдийн засаг:** Батлан хамгаалахын технологи нь эдийн засгийн инновацын салбарыг хөгжүүлдэг.
- **Эмзэг байдал:** Газар нутгийн хэмжээ бага; эрчим хүчний импортоос хамааралтай; БНХАУ-ын эдийн засгийн нөлөө их.

Нэгдсэн дүгнэлт (хувилбар): Өмнөд Солонгосын чадавх нь зөвхөн нэг салбарт биш, харин дипломат, мэдээлэл, цэрэг, эдийн засгийн уялдаа холбоо дээр тулгуурлаж байна. Гэхдээ газар нутгийн хэмжээ, эрчим хүчний аюулгүй байдал нь эмзэг цэг хэвээр байна.

Өмнөд Солонгосыг Япон, Хятадтай харьцуулбал гурван улсын DIME шинжилгээ нь бүс нутгийн хүчний тэнцвэрийг тодорхой харуулдаг: Солонгос АНУ-тай холбоо, технологийн инновацаар ялгардаг; Япон дипломат нэр хүнд, эдийн засгийн тогтвортой байдлаар хүчтэй; БНХАУ бүх талд өргөн цар хүрээтэй боловч мэдээлэл, хууль ёсны байдалд эмзэг.

Хиймэл оюун ухаан ашиглаж байгаа ч логик уялдааны суурь болох системийн онол арга зүйн, философийн мэдлэгийн талаар зөв ойлголттой байх нь үнэлгээ хийж буй хүнд тавигдах зүйн шаардлага байсаар байна. Энэ бодлого (стратегийн)

боловсруулах үеийн үнэлгээний арга нь бодлого (стратегий) боловсруулах шатны хувилбар боловсруулалтын үед бусад аргуудтай хослон хэрэглэх нь зохимжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Цахим хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээ болон хиймэл оюун ухаан хурдацтай хөгжиж буй өнөөгийн нөхцөлд удирдагчийн үүрэг улам бүр нарийсаж, удирдуулах бус чиглүүлэн манлайлах чадварыг тасралтгүй хөгжүүлэх шаардлага нэмэгдэж байна. Ийм орчинд бодлого (стратегий) боловсруулах үйл явц нь улам өндөр түвшний үнэлгээний арга зүй, логик уялдааны онолын зөв мэдлэгийг шаардаж байна. Албан хаагч хиймэл оюун ухаан ашиглаж баримт бичиг боловсруулж байгаа ч үнэлгээний суурь логик, системийн сэтгэлгээний шаардлага хэвээр байгааг байнга анхаарах хэрэгтэй байна.

Энэхүү өгүүлэл нь стратегийн үнэлгээний онолпрактикийн үндсийг системийн шинжилгээний үүднээс тайлбарлаж, үндэсний аюулгүй байдлын орчныг үнэлэхэд шаардлагатай институц хоорондын уялдаа, хүчин зүйлсийн харилцан хамаарлыг цогцоор нь авч үзсэнээрээ онцлог гэж үзэж байна. Стратегийн үнэлгээ нь олон улсын болон дотоод орчны олон талт субъект, ашиг сонирхлын огтлолцлыг материаллаг болон материаллаг бус хүчин зүйлсээр зэрэг шинжлэх шаардлагатайг онцолж, бодит нөхцөл байдлыг үзэл суртлын нөлөөнөөс ангилан үнэлэхийн ач холбогдлыг ч тодотгож байна.

Улсын төр засгийн чадавхыг дипломат, мэдээлэл, цэрэг, эдийн засгийн дөрвөн чиглэлээр системтэй үнэлдэг **DIME арга нь** институц хоорондын уялдаатайгаар төрийн институцийн чадавхыг тодорхойлох оновчтой арга гэж үзэж байна. Үүнтэй уялдан Клаузицийн “хүндийн төв” болон “эмзэг цэг”-ийн шинжилгээ нь тухайн субъектийн стратегийн давуу болон сул тал, тэдгээрийн систем доторх байрлал, нөлөөллийн логикийг тодорхойлох онолын чухал арга болохыг онцолж байна.

Материалд улс төрдипломат оролцоо, мэдээллийн экосистем, цэргийн бэлэн байдал, эдийн засгийн бүтцийн хүчин зүйлсийг олон улсын жишээтэй харьцуулан тайлбарлаж, стратегийн үнэлгээний үр дүн нь үндэсний аюулгүй байдлын, салбар дундын, салбарын бодлогын хувилбар боловсруулах, аюулгүй байдлын орчныг урьдчилан таамаглах, институц хоорондын зохицуулалтыг сайжруулахад суурь үндэс болдгийг харуулж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Cambridge Dictionary. 2026. “Strategy.” <https://dictionary.cambridge.org/dictionary/english/strategy>.
2. *Feild Manual FM 3-0 Operations*. 2022. <https://irp.fas.org/doddir/army/fm3-0.pdf>.
3. NATO and Ministry of Defence (UK). 2019. *Allied Joint Publication-5: Allied Joint Doctrine for the Planning of Operations*. AJP-5, Edition A Version 2, UK Change 1. NATO; Ministry of Defence (UK).
4. Popov, I. M., and M. M. Khamzatov. 2018. *Voina Budushchego: Kontseptual'nye Osnovy i Prakticheskie Vyvody: Ocherki Strategicheskoi Mysli*. Izdanie tret'e, Ispravlennoe. Iskustvo Voiny. Kuchkovo pole.
5. Ronnie S. Catpon. 2026. “Law Enforcement As an Instrument of National Power.” <https://afsa.org/law-enforcement-instrument-national-power>.
6. Strange, Joe. 2005. *Centers of Gravity & Critical Vulnerabilities: Building on the Clausewitzian Foundation So That We Can All Speak the Same Language*. Perspectives on Warfighting 4. Marine Corps University.